



**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК-ИЙН  
ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2025.12.05

Улаанбаатар хот

№	АРГА ХЭМЖЭЭ	ХУГАЦАА	ХАРИУЦАХ НЭГЖ	БИЕЛЭЛТ	Хувь
1	Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээнд оролцох, компанийн ажилтнуудын дунд салбарын түүхэн хөгжил, цаашдын зорилтын талаар танилцуулга, мэдээлэл өгөх арга хэмжээ зохион байгуулах	2025 оны 04, 05 дугаар саруудад	ЗУХ СТХ НБҮАЗХ ХЗА	<p>Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэх хүрээнд 2025.05.23-ны өдөр зохион байгуулагдсан арга хэмжээнд компанийг төлөөлөн зарим ажилтан оролцсон. Тус түүхэн ойг тохиолдуулан иргэний нисэхийн салбарын түүхэн хөгжил, цаашдын зорилтын талаар танилцуулга, мэдээлэл өгөх арга хэмжээг компанийн ажилтнуудын дунд зохион байгуулсан.</p> 	100
2	Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан “Хөх тэнгэрийг эзэгнэсэн 100 жил” номд оруулах компанийн танилцуулгыг бэлтгэж өгөх ажлыг зохион байгуулах	2025 оны 05 дугаар сард	ЗУХ НБҮАЗХ	Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан “Хөх тэнгэрийг эзэгнэсэн 100 жил” номд компанийн танилцуулгыг бэлтгэж, оруулсан.	100

					
3	“Монгол Улсын Нисэх хүчний 100 жил”-д зориулсан шуудангийн маркийн нээлтийн ёслолын арга хэмжээг Зам, тээврийн яам, “НУБИЭ” ХХК-тай хамтран зохион байгуулах	2025 оны 05, 07 дугаар саруудад	ЗУХ СТХ НБУАЗХ	<p>“Монгол Улсын Нисэх хүчний 100 жил”-д зориулсан шуудангийн маркийн нээлтийн ёслолын арга хэмжээг 2025.07.04-ний өдөр Зам, тээврийн яам, “НУБИЭ” ХХК-тай хамтран зохион байгуулсан.</p> 	100
4	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Чингис хаан” олон улсын нисэх буудал дахь “Хүндэт зочны танхим”-ын гадна талбайд мод тарих ажлыг зохион байгуулах	2025 оны 05, 10 дугаар саруудад	ЗУХ СТХ НБУАЗХ ХЗА	<p>Компани 2025 онд “Чингис хаан” ОУНБ дахь Хүндэт зочны танхимын гадна талбайд 360 ширхэг мод тарих, 300м<sup>2</sup> талбайг зүлэгжүүлэх, 95м<sup>2</sup> талбайд мандлын цэцэг суулгах буюу цэцэгжүүлэлтийн ажлыг хийхээр төлөвлөн, зардлыг төсөвт суулган, Хувьцаа эзэмшигчдээр батлуулсан. Төлөвлөсний дагуу “Чингис хаан” ОУНБ дахь Хүндэт зочны танхимын гадна орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах зорилгоор 2025.06.23-07.01-ний хоорондох хугацаанд 121м<sup>2</sup> талбайд 6,050 ширхэг мандлын цэцэг, 30м<sup>2</sup> талбайд зүлэг тарих, намрын улиралд 500-700 хайлаас мод нөхөн тариулахаар “Оюу гарден” ХХК-тай Г-2025/21 дугаартай гэрээ байгуулан, гэрээний дагуу 2025.06.23-07.01-ний хоорондох хугацаанд 6,050 ширхэг</p>	100

				мандлын цэцэг, 30м <sup>2</sup> талбайд зүлэг тарих ажлыг хийж гүйцэтгүүлсэн.	
5	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар компанийн ажилтнуудад мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах	2025 оны 06 дугаар сард	ЗУХ	<p>Компанийн ажилтнуудад “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” талаар мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах хүрээнд Авлигатай тэмцэх газрын вэбсайтад байршуулсан 6 сэдэв бүхий сургалтын видео хичээлийг нийт ажилтанд и-мэйлээр хүргүүлж танилцуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Авлига гэж юу вэ?</li> <li>2. Авлигын гэмт хэрэг гэж юу вэ?</li> <li>3. Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?</li> <li>4. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр гэдэг нь</li> <li>5. Авлигаас хэрхэн урьдчилан сэргийлдэг вэ?</li> <li>6. Авлигыг хэрхэн мэдээлэх вэ?</li> </ol> 	100
6	Компанийн ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах	2025 оны 09-10 дугаар сард	ЗУХ СТХ НБУАЗХ	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн байгууллагыг сонгон шалгаруулах тендер зарлаж, сонгон шалгаруулалтад оролцож шалгарсан “Интернэйшнлмедикал сентер” ХХК-тай 2025 оны 10 дугаар сард гэрээ байгуулан компанийн нийт ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, багц шинжилгээнд бүрэн хамруулсан.	100
7	Компанийн ажилтнуудыг “Монгол бичиг”-ийн ахисан түвшний сургалтад хамруулах	2025 оны 09-11 дүгээр сард	ЗУХ СТХ НБУАЗХ ХЗА	“Монгол хэлний тухай хууль” болон “Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр III”-ийн хэрэгжилтийг хангах, түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд ажилтнуудад Монгол бичгийн ахисан түвшний мэдлэг олгох сургалтыг 2025 оны II-IV улиралд зохион байгуулахаар компанийн “Хүний нөөцийн 2025 оны сургалтын төлөвлөгөө”-нд тусгасны дагуу Монгол бичгээр хөрвүүлж компьютерт шивж сурах онолын	100

				мэдлэг, практик чадвартай болгох зорилго бүхий 20 цагийн танхимын сургалтад компанийн ажилтнууд 2025.10.17-ны өдрөөс 2025.11.18-ны өдрүүдэд бүрэн хамрагдсан.	
8	Компанийн ажилтнуудын дунд “Цусаа бэлэглэе” цус хандивлах өдөрлөгийг зохион байгуулах	2025 оны 10-11 дүгээр сард	ЗУХ СТХ НБҮАЗХ ХЗА	Сайн дурын үндсэн дээр “Цусаа бэлэглэе” цус хандивлах өдөрлөг зохион байгуулах талаар компанийн нийт ажилтанд уриалга, холбогдох мэдээллийг хүргүүлсэн ба “Цусаа бэлэглэе” өдөрлөгийн хүрээнд 2025.11.12-ны өдөр Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Эдийн засагч, Захиргааны мэргэжилтэн нар цусаа хандивласан.	100

---ooOoo---